



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 3/64

Ховд

Д.Ариунбилэгийг шилжүүлэн томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, 44.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга Дашнямын Ариунбилэгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргаар 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан болон гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хариуцлагатай ажиллахыг /Д.Ариунбилэг/-т үүрэг болгосугай.

4. Д.Ариунбилэгт төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-10-5 дахь шатлал буюу 1088657 төгрөг /нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоон/-өөр, зэрэг дэвийн нэмэгдлийг 28 хувиар, удаан жилийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож олгохыг Санхүү аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-т зөвшөөрсүгэй.


ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 00711

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2020 оны 07 дугаар сарын 31-ний
өдрийн Б/64 дүгээр тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд - Төрийн захиргааны удирдлагын хэлстийн дарга
- Гишүүд: Б.Гантөмөр - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Б.Энхмандал - Санхүү аж ахуйн тасгийн нягтлан бодогч

-ооо-